

Монгол эрдэмтдийн сурах бичгийн агуулга, арга зүйн шаардлагыг харьцуулсан судалгааны үр дүн

С.Цогбадрах*

Боловсролын хүрээлэн,
Сурах бичиг, сургалтын орчин, судалгааны сектор

Хураангуй

Сурах бичгийн талаарх төрөөс баримтлах бодлого, бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийн зорилго, зорилтын хүрээнд нийцүүлэн бага дунд боловсролын хэвлэмэл сурах бичгийн агуулгад 3 шаардлагад хамааралтай 5 шалгуур, арга зүйд 2 шаардлагад хамааралтай 2 шалгуур үзүүлэлт, нийт 7 шаардлагад хамааралтай 7 шалгуур үзүүлэлт (тогтвортой хөгжлийн хөтөч болох байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийн талаар тусгасан байх Эдийн засаг, хүрээлэн буй орчин, нийгмийн хөгжлийн талаарх асуудлыг тогтолцоогоор харуулах даалгавар боловсруулсан байх; жендэрийн мэдрэмжтэй байдлыг тусгасан байх-сурах бичгийн сэдвүүд жендэрийн мэдрэмжийг тусгасан эсэх; онол, практикийн тэнцвэртэй харьцаатай байх -сурах бичгийн нийт сэдэв шинжлэх ухааны мэдлэг эзэмшүүлэхэд чиглэж бичигдсэн эсэх, сурах бичгийн нийт сэдэв онол ба туршилт ажлын харьцааг хангасан байх, сурах бичгийн нийт сэдэв онол ба дадлага ажлын харьцааг хангасан байх) -ийг судалгаанд үндэслэж шинээр боловсруулж, бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичгийн агуулгад тавих 9 шаардлагыг монгол эрдэмтдийн агуулгад тавих шаардлагатай харьцуулж үзэхэд 10-70 хувьтай, аргазүйд тавих шаардлага 22-66 хувьтай тохирч байгааг судалгаагаар тогтоосон.

Түлхүүр үг

Сурах бичгийн агуулга, арга зүй, шаардлага, шалгуур

Удиртгал

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлоготой уялдуулан Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байгааг боловсролын эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлжээ. Тухайлбал, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын зорилго нь иргэн бүр авьяас чадвараа хөгжүүлэн, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах мэдлэг, чадвар, чадамжийг эзэмшин, ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж, үндэсний нийтлэг үнэт зүйлсийг өвлөн насан туршдаа суралцах боломжоор хангах зорилго бүхий үйл ажиллагааны цогц тогтолцоо бүрдүүлэхэд оршино гэж заажээ.

Суурь боловсролыг амьдрах ухаан, шинжлэх ухааны мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадамж эзэмших үе хэмээн хөгжүүлнэ гэж заажээ (Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, 2015, х.189).

Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн зорилго нь суралцагч бүрийг сурах арга барил, амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадвар эзэмших, үндэсний хэл, түүх,

соёлоо дээдлэн хөгжүүлэх, ардчилсан, хүмүүнлэг үзэлтэй иргэн төлөвших боломж олгоход оршино.

Байгалийн ухааны хичээлийн зорилго нь суралцагч байгалийн юмс, үзэгдлийг танин мэдэх арга барилаа хөгжүүлж, тасралтгүй суралцдаг, хүрээлэн буй орчиндоо ээлтэй, түүнийг хайрлан хамгаалахад хувь нэмрээ оруулдаг иргэн болж төлөвшинө гэж заажээ (Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр, 2015, х.58).

Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага MNS5418:2008 Монгол улсын стандартыг бага, суурь, бүрэн дунд боловсролын бүх түвшний сурах бичигт нийтлэг хэрэглэхэд учир дутагдалтай байна. Сурах бичиг бүр судлах агуулга, суралцах арга зүйн шийдлээрээ бусад ном зохиолоос ялгаатай.

Иймд суралцагчдын сурах бичиг зохиоход 2008 онд батлагдсан MNS 5418:2008 стандарт буюу “Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага”-ын зарим шаардлагыг боловсролын бодлого; хөтөлбөрийн шинэчлэл; өөрчлөлтөд нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай юм. Монгол эрдэмтдийн сурах бичгийн агуулга, арга зүйд тавих шаардлагын судалгааны үр дүнг одоо мөрдөж буй сурах бичгийн агуулга, арга зүйд тавих шаардлагатай харьцуулан судалж, сурах бичгийн талаарх

*Холбоо барих зохиогч:tsogoo.1207@yahoo.com

төрөөс баримтлах бодлого, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийн зорилго, зорилтод нийцүүлэн боловсронгуй болгоход оршино.

Судлагдсан байдал

Агуулга нь сүүлийн үеийн мэдээлэл, тоо баримт, дүрмийн алдаагүй; нэг ухагдахуунаас нөгөө ухагдахуунд шилжих дэс дараалал нь хүнд, хөнгөний хувьд эрэмбэ дараалалтай, дэвших зарчмаар бичигдэх; дасгал даалгавар нь агуулгадаа тохирсон; суралцагчдад бүрэн эзэмших боломж олгохоор системтэй зохиогдсон байх; дасгал даалгавар нь хүүхдийн өдөр тутмын амьдрал, хэрэглээтэй нь холбосон байх; бодит амьдрал дахь жишээгээр баяжуулсан байх; ажиглалт судалгаа хийлгэх, мэдлэгээ хэрэглэх, шинэ нөхцөлд шилжүүлэн ашиглах үйл ажиллагаа явуулахаар дасгал, даалгавар боловсруулах, чадвар, мэдлэгээ ашиглан тухайн нөхцөлөөс шинэ мэдлэг бие дааж эзэмших боломж олгох дасгал даалгавартай байх, хүүхдийн бие даасан, бусадтайгаа хамтран ажиллах үйл ажиллагааг дэмжсэн байх гэж үзсэн байна (Цэдэвсүрэн, 2001, х.96).

Бидний эргэн тойронд байгаа бүхий л юмс, үзэгдэл өргөн утгаараа байгалийн ухааны хичээлийн судлагдахуун буюу агуулга юм. Иймээс суралцагчдын эрэлт хэрэгцээ, сонирхлыг тооцон байгалийн ухааны хичээлээр голлон олж авдаг дараах чадваруудад баримжаалан хичээлийн агуулгыг чөлөөтэй сонгох зүйтэй юм. Тухайлбал, Ангилах, төрөл, зүйлийг тогтоох, онцлог ба нийтлэг шинж чанарыг нь харьцуулан илрүүлэх, зүй тогтол, зарчмыг олж харах, нотлох, батлах, өөрчлөлт, хувирлын тухай мэдлэг бүтээх, туршилтыг төлөвлөх, багаж төхөөрөмж ашиглаж сурах, тэмдэглэл хөтлөх арга барилыг эзэмших, шийдвэрлэх асуудлыг олж харах, томьёолох, таамаглал дэвшүүлэх, таамаглалаа батлах, үр дүнг түгээн дэлгэрүүлэх зэрэг болно (Оюунцэцэг, ба бус, 2005, х.5).

Үндэсний хөгжлийн, тэр дотроо боловсролын хөгжлийн бодлого, боловсролын стандарт, агуулгад нийцсэн байх; сургалтын төлөвлөгөөнд байгаа цагт тохирсон агуулгатай байх; дээд болон доод түвшин, ангийн сурах бичгийн агуулгатай залгамж холбоотой байх; тоо баримтын хувьд үнэн, зөв алдаагүй байх; суралцагчийн хэрэгцээг хангасан байх; хүүхдийн хөгжил, танин мэдэхүй, суралцахуйн зүй тогтолд нийцүүлсэн байх гэжээ (Нарантуяа, 2012, х.35).

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн профессор багш нар ном, сурах бичгийн агуулгад тавих үндсэн шаардлагыг дараах агуулгаар

тодорхойлсон байна.

Тухайлбал, Танин мэдэхүйн хөгжлийн үе шат, нас сэтгэхүйн онцлогт тохирсон; боловсролын түвшингийн залгамж холбоог хангасан; шинжлэх ухаан, технологийн ололтыг өргөн тусгасан; агуулгыг томсгож, инвариант чанарыг хангасан байх; Монгол улсын хөгжлийн болон даяаршлын тулгамдсан асуудлыг хөндсөн; суралцагчдын сонирхол, хэрэгцээнд нийцүүлж, практик амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн, мэдлэгийн бусад салбартай нягт уялдсан; хууль, дүрмийг суралцагчийн танин мэдэхүйн түвшинд тохируулан буулгаж, зөв оновчтой томьёолсон, шинжлэх ухааны буруу ойлголтыг; агуулгын багтаамж, бүтэц нь сургалтын төлөвлөгөөнд нийцэж, хичээлийг төлөвлөх, зохион байгуулах нөхцөлийг хангасан байна гэж үзсэн байна (Гөлгөө, 2006. х.5).

Гадаад хэлний сурах бичгийн агуулгад тавих шаардлагыг дараах хэлбэрээр тодорхойлсон. Үүнд: Сургалтын зорилго, хөтөлбөртэй уялдсан байдал, (Номын агуулга үндэсний хөтөлбөртэй дүйцэж байх, хөтөлбөрийн агуулгыг бүхэлд нь харгалзсан байх, хөтөлбөрийн агуулгаас давсан зүйлсийг тусгайлан тэмдэглэх)

Шинжлэх ухааны ололттой уялдсан байдал. (Сурах бичгийн агуулга өнөөгийн сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлал, хэл шинжлэлийн онолын түвшинд бичигдсэн байх, шинжлэх ухааны гол нэр томьёонуудад хангалттай тайлбар өгсөн байх, бусдын зохиол, бүтээлээс авсан зүйлдээ эшлэл, зүүлт хийх, олон улсын СИ системийн тэмдэг, символ ашиглах, хүнд ойлголтыг тайлбарлахдаа харьцуулалт ашиглах, харьцуулалт нь оновчтой байх, хийсвэр ойлголтыг тайлбарлахдаа жишээ татах).

Нийгэм, түүх, соёлын асуудлууд. Сурах бичигт байгаа материал түүхэн үндэстэй, шинэ материалыг хүүхдэд ойлгомжтой өгч чадахаар боловсруулсан байх, эзэмшсэн шинэ мэдлэгээ амьдралд хэрэглэх жишээтэй, суралцагчдын бодит амьдралаас авсан жишээтэй, тогтвортой хөгжлийн асуудлыг хэр ойлгомжтой тайлбарласан байх зэрэг болно.

Сурах бичиг дэх жендерийн асуудал: (Сурах бичгийн хавтсанд хэдэн хүний зураг байна вэ?, сурах бичигт нийт хэдэн хүний зураг байна вэ?, үүнээс хэд нь эмэгтэй, хэд нь эрэгтэй хүний зураг байна вэ?, Эрэгтэйчүүд юу хийж байгаагаар гарч байна вэ?, эмэгтэйчүүд юу хийж байгаагаар гарч байна вэ?, сурах бичгийн текстүүдэд жендерийн мэдрэмж хэр байна вэ?, эрэгтэй, эмэгтэй хүүхдийн сурах аргын онцлогийг хэр тусгаж вэ?, сурах бичгийн дасгал, даалгавар нь гагцхүү цээжлэхэд чиглэсэн үү) (Туяа, 2005, х. 44, 45).

Орчин үеийн сурах бичигт тавих шаардлага нь: Сургалтын зорилго, хөтөлбөрийн уялдсан байдал; номын агуулга үндэсний хөтөлбөрийн агуулгаас давсан зүйлийг тусгайлан тэмдэглэсэн эсэх; шинжлэх ухааны ололттой уялдсан байдал; бусдын зохиол бүтээлээс авсан эшлэл, зүүлт; сурах бичиг дэх дасгал, даалгавар; нийгэм, түүх соёлын асуудлууд; сурах бичигт байгаа материалын түүхэн үндэс, суралцагчдын бодит амьдралаас авсан жишээ; ард түмний соёл, түүхийн уламжлал сурах бичигт хэр туссан; сурах бичиг ба тогтвортой хөгжлийн асуудал; сурах бичгийн жендерийн мэдрэмж гэсэн агуулгыг багтаана гэж үзжээ (Бэгз, 2005, х.3-4).

Сурах бичгийн агуулга нь танин мэдэхүйн талаас нь боловсролын тухайн түвшинд харгалзах хичээл бүрээр суралцагч юу эзэмших; хүрээлэн буй бодит болон нийгэм орчноо ойлгоход нь юу тус болох; үйл хөдлөл болон хандлагын, онолын хийгээд дадлага чадварын хөгжилд; суралцагчдын боловсролд юу тус нэмэр болох гэж тодорхойлжээ (Лхагважав, 1999, х. 53).

Нийгмийн ухааны сурах бичгийн агуулга, түүнд тавих шаардлагыг доорх хэлбэрээр тодорхойлсон байна. Үүнд: Бага ангийн суралцагчийн мэдлэг эзэмших үйл ажиллагааны физиологийн болон сэтгэл зүйн үндэстэй холбоотойгоор агуулгыг томъёолсон байдал; Нийгмийн үйл явц үзэгдлийн талаар сэтгэхүйдээ ухаарч эргэцүүлэх, боловсруулах болон мэдлэг, чадварын үр дүнг үнэлж, дүгнэхтэй уялдсан байдал; нийгмийн үйл явц, үзэгдлийн талаарх мэдээллийг мэдрэхүйн эрхтний тусламжтайгаар хүлээн авах үйл ажиллагаа, сэтгэж хүлээн авах үйл ажиллагааг хэрэглээ болгох чадвар; нийгмийн ухааны ойлголт, ухагдахуунаар хүлээн авах чадварт нийцсэн байх; суралцагчдын нас, сэтгэцийн онцлог (сонинч, өөдрөг сэтгэл, сайхан сэтгэл, анхаарлын чанар гэх мэт) хэрэгцээнд хэр нийцэж, хувийн болон гэр бүл, найз нөхөд, орон нутаг, улс эх орны хүрээн дэх бодит асуудалтай уялдах; бага боловсролын нийгмийн ухааны цөм агуулга (суурь үндсэн ойлголт, чадвар хийгээд нэр томъёо, үг хэллэг) нь суралцагчдад ойлгомжтой энгийн байх; цөм агуулга нь суралцагчийн танин мэдэхүйн хөгжил хийгээд биеэ зөв авч явах, зан заншил, ёс суртахуун, хүрээлэн буй орчны эерэг, сөрөг нөлөөлөл, хүмүүжил, төлөвшилттэй холбоотой байх; суралцагч өөрөө өөрийгөө үзэх үзэл, зан үйлдээ сэтгэл, ухамсартай, эзний ёсоор бүтээлчээр хандах хандлага, эх орон, улс үндэстнээ хайрлах, бахархах үзэл, итгэл, үнэмшил төлөвшүүлэхэд чиглэсэн байх зэрэг шаардлагуудыг авч үзжээ (Дэлгэрсайхан, 2013. х. 109-112).

Д.Гарвины чанарын хэмжүүрт тулгуурлан чанартай сурах бичгийн бүтээгдэхүүнд тавих шаардлагыг доорх агуулгаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Ээлтэй байдлын шалгуур. (Хэмжээ, жин, өнгө тохиромжтой, соёлын, шашны, үндэстний онцлог, бусад хэрэгцээг хангаж буй байдалд суралцахуйн үр дүнгээ үнэлэхэд туслах байдал).
2. Өвөрмөц байдлын шалгуур. Бусдаас ямар ялгаатай, хувь хүнд хэр зэрэг тохирох, ямар арга технологийг ашигласан, суралцагчдын ялгаатай байдлыг харгалзсан агуулга, хэрэглэгдэхүүн, үнэлгээ гэх мэт.
3. Найдвартай байдлын шалгуур. Үүнийг хэрэглэснээр суралцагчдад ямар боломж, эрсдэл үүсэхийг үнэлнэ. Сурах бичгийн мэдээлэл үнэн, ойлгомжтой байх шаардлагатай.
4. Нийцэл зохицлын шалгуур. Тухайн бүтээгдэхүүн стандартад хэр нийцсэнийг хэмждэг. Төрийн болон боловсролын бодлого, стандарт хөтөлбөрийн үзэл баримтлал.
5. Бат бөх чанарын шалгуур. Хэрэглэх хугацаа-агуулга баталгаатай шинэлэг мэдээлэлтэй эсэхийг үнэлнэ. Ашигласан хугацаа-цаасны чанар, хэвлэлийн чанар, ашиглалтын арчилгаа.
6. Хэрэгцээний шалгуур. Суралцагчдын хэрэгцээнд хэр зэрэг тохирсныг үнэлнэ.
7. Гоо сайхан үзэмжийн шалгуур. Сурах бичгийн гарчгийн томъёолол, үдээс, үсгийн хэв, хэмжээ, схем, зураг, график, түүний тайлбар бусад агуулга нас, биеийн онцлогт тохирох эсэх, ямар мэдрэмж төрүүлдэг.
8. Үнэ цэнийн шалгуур. Суралцагчдын сонирхлыг хэр зэрэг татаж буйг үнэлдэг.
9. Багш, эцэг эх, суралцагчдад эерэг ойлголт өгөх, гадаад үзэмж, агуулга, хэвлэлийн чанар хэмээн тодорхойлсон (Оюунчимэг, 2013, х. 25).

Сурах бичгийн агуулгад тавих шаардлагыг хичээлийн хөтөлбөрийн агуулгыг нэгтгэн зангидсан, баримт сайтай, тухайн шинжлэх ухааны логик дарааллыг оновчтой тусгасан байх; бичмэл хэсэг, зураглал, үзүүлэн тайлбар нь тодорхой ойлгомжтой, сонирхол татсан, амьдрал ахуйд хэрэглэх мэдлэг, дадлага, хандлагыг тодруулсан; бүлэг, дэд бүлэг, хэсэг бүр ялгаатай, аль болох урт өгүүлбэрээс зайлсхийсэн байх; агуулгыг баяжуулах нэмэлт мэдээлэл, дасгал, уншиж үзэх материал болон ном зүйн эшлэлтэй байх; багшийн лекцийн дараа суралцагчид бичиж тэмдэглэж болохоор, бие даан суралцахад нь суурь болохуйц байх; суралцагчид болон

бусад сонирхогч хүмүүст мэдээллийн эх сурвалж болохын зэрэгцээ, судлах материалыг эзэмших арга барил, загвар, чанарыг тусгасан байх гэж тодорхойлсон байна (Наранчимэг, 1999, х. 226).

Сурах бичгийн сэтгэлзүйн болон сурган хүмүүжүүлэх зүйн шаардлага:

А. Сурах бичигт тавих сэтгэл зүйн шаардлагын үзүүлэлт. Суралцагчдын сурч танин мэдэх сэдэл, сонирхлыг өдөөн хөгжүүлэх нөлөөтэй эсэх; тухайн насны суралцагчдын насны онцлогийг харгалзсан эсэх; тухайн насны суралцагчдын сэтгэцийн хөгжлийн онцлогийг харгалзсан эсэх; суралцагчдын бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх нөлөөтэй эсэх, суралцагчдын бие дааж сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх нөлөөтэй эсэх.

Б. Сурах бичигт тавих сурган хүмүүжүүлэх зүйн шаардлагын үзүүлэлт.

Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг үндэслэн хийсэн эсэх; тухайн судлагдахууны гол гол асуудлыг бүрэн тусгасан эсэх; тухайн судлагдахууны тулгуур ухагдахууныг бүрэн багтаасан эсэх; судлагдахууны нийт агуулгыг оновчтой бүлэглэсэн эсэх; суурь ухагдахууны тодорхойлолтыг суралцагчдад ойлгомжтой бичсэн эсэх; бүлэг, сэдвүүд хоорондоо утгын уялдаа холбоотой эсэх; бүлэг, сэдэв бүрийн агуулга суралцагчдын амьдралтай холбоотой эсэх; шинжлэх ухааны мэдлэг болон практик хэрэглээ хоёрын харьцаа оновчтой эсэх; өгүүлбэрийн хэмжээ суралцагчдын нас, танин мэдэхүйн онцлогт тохирсон эсэх; шинжлэх ухаан, танин мэдэхүйн сүүлийн үеийн ололт амжилтаас тусгасан эсэх; орчин цагийн Монгол хэлний дүрэмд нийцэж буй эсэх, алдаагүй эсэх; эх бичвэрийн төгсгөлд буй асуулт тодорхой, бүтээлч эсэх, дасгал, даалгавар, бодлого байгаа эсэх; дасгал, даалгавар, бодлого нь суралцагчдад ойлгомжтой, тоо, төрлийн хувьд тохирсон эсэх, суралцагчдын бие дааж сэтгэн бодох, бүтээлч чадварыг хөгжүүлэх нөлөөтэй эсэх; дасгал, даалгавар, бодлого, асуулт зэрэг нь суралцагчдын танин мэдэх онцлогийг харгалзсан эсэх; зураг, бүдүүвч, хүснэгт байгаа эсэх, зураг, бүдүүвч, хүснэгт суралцагчдад ойлгомжтой, сурах бичигт ашигласан материал, ном зүй байгаа эсэх гэж авч үзжээ.

Сурах бичгийн сэтгэлзүйн болон сурган хүмүүжүүлэх зүйн шаардлага:

А.Сурах бичигт тавих сэтгэл зүйн шаардлагын үзүүлэлт. Суралцагчдын сурч танин

мэдэх сэдэл, сонирхлыг өдөөн хөгжүүлэх нөлөөтэй эсэх; тухайн насны суралцагчдын насны онцлогийг харгалзсан эсэх; тухайн насны суралцагчдын сэтгэцийн хөгжлийн онцлогийг харгалзсан эсэх; суралцагчдын бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх нөлөөтэй эсэх, суралцагчдын бие дааж сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх нөлөөтэй эсэх.

Б.Сурах бичигт тавих сурган хүмүүжүүлэх зүйн шаардлагын үзүүлэлт.

Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг үндэслэн хийсэн эсэх; тухайн судлагдахууны гол гол асуудлыг бүрэн тусгасан эсэх; тухайн судлагдахууны тулгуур ухагдахууныг бүрэн багтаасан эсэх; судлагдахууны нийт агуулгыг оновчтой бүлэглэсэн эсэх; суурь ухагдахууны тодорхойлолтыг суралцагчдад ойлгомжтой бичсэн эсэх; бүлэг, сэдвүүд хоорондоо утгын уялдаа холбоотой эсэх; бүлэг, сэдэв бүрийн агуулга суралцагчдын амьдралтай холбоотой эсэх; шинжлэх ухааны мэдлэг болон практик хэрэглээ хоёрын харьцаа оновчтой эсэх; өгүүлбэрийн хэмжээ суралцагчдын нас, танин мэдэхүйн онцлогт тохирсон эсэх; шинжлэх ухаан, танин мэдэхүйн сүүлийн үеийн ололт амжилтаас тусгасан эсэх; орчин цагийн Монгол хэлний дүрэмд нийцэж буй эсэх, алдаагүй эсэх; эх бичвэрийн төгсгөлд буй асуулт тодорхой, бүтээлч эсэх, дасгал, даалгавар, бодлого байгаа эсэх; дасгал, даалгавар, бодлого нь суралцагчдад ойлгомжтой, тоо, төрлийн хувьд тохирсон эсэх, суралцагчдын бие дааж сэтгэн бодох, бүтээлч чадварыг хөгжүүлэх нөлөөтэй эсэх; дасгал, даалгавар, бодлого, асуулт зэрэг нь суралцагчдын танин мэдэх онцлогийг харгалзсан эсэх; зураг, бүдүүвч, хүснэгт байгаа эсэх, зураг, бүдүүвч, хүснэгт суралцагчдад ойлгомжтой, сурах бичигт ашигласан материал, ном зүй байгаа эсэх гэж авч үзжээ.(Ичинхорлоо, 2013, х.117-118). Судлаачдын сурах бичгийн агуулгын шаардлагын судалгааны үр дүнг тоон талаас нь авч үзвэл: Эрдэмтэн, судлаач Н.Бэгз 11 шаардлага, Ж.Нарантуяа 6, Л.Туяа 4, Ц.Дэлгэрсайхан 5, Ч.Лхагважав 4, Д.Гөлгөө (ШУТИС-ийн редакторын зөвлөл) 7, Д.Гарвин 9, Н. Цэдэвсүрэн 6 Ш.Ичинхорлоо 16, Н.Наранчимэг 6-г тус тус боловсруулжээ. Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих сурах бичиг зохиоход хэрэглэж байна.

Судалгааны арга зүй

Энэхүү судалгааны ажлыг хийхдээ сурах бичгийн талаарх монгол эрдэмтдийн сурах

бичгийн шаардлагын талаарх зарим судалгааны үр дүнг одоо мөрдөж буй бага, дунд хэвлэмэл сурах бичигт тавих шаардлагын (MNS5418:2008) сурах бичгийн эхийн агуулгад тавих 9 шаардлага (5.1.1-5.19), арга зүйд тавих 8 (5.2.1-5.2.8) шаардлагыг судалгааны арга зүйн үндэс болгож ашигласан. Дээрх сурах бичгийн эхийн агуулгад тавих (5.1.1-5.19) 9 шаардлагыг хүснэгт 1, арга

зүйд тавих 8 (5.2.1-5.2.8) шаардлагыг хүснэгтэд 2-д тусгаж, монгол эрдэмтдийн сурах бичгийн агуулга, арга зүйн талаарх судалгааны дүнтэй харьцуулж тодорхой үр дүнг гаргасан болно. Ном зохиол болон баримт бичиг судлах арга, харьцуулалтын арга, тайлбарлах аргыг хослуулан хэрэглэсэн.

Судалгааны үр дүн

Хүснэгт 1

Одоо мөрдөж байгаа сурах бичгийн агуулгад тавих шаардлагыг монголын эрдэмтдийн сурах бичгийн агуулгад тавих шаардлагатай харьцуулсан судалгааны дүн

Хэвлэмэл сурах бичгийн агуулгад тавих шаардлага		Эрдэмтдийн нэр	Агуулга нь танин мэдэхүйн хөгжлийн үе шат, нас сэтгэхүйн онцлогт тохирсон, боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоог хангасан байна.	Боловсролын стандартын цогц чадамжийн ай бүрийн агуулгыг боловсролын болон суралцагчийн танин мэдэхүйн тухайн түвшинд бүрэн эзэмших боломжтой,тэдний мэдлэг бүтээх үйл ажиллагаа нь үр өгөөжтэй байхаар сурах бичгийн агуулгыг сонгоно.	Ухагдахуун, хууль, зүй тогтлыг хэрэглээ болон танин мэдэхүйн түвшинд тохируулан буулгаж, зөв оновчтой томъёолсон, шинжлэх ухааны хувьд алдаагүй байна.	Дидактикийн оновчтой шийдлээр агуулгын нэгжийг томсгон нэгжилж, бүтэцчилэх үндсэн дээр агуулгын айн инвариант чанарыг хангасан байна.	Агуулга нь Монгол улсын хөгжлийн болон даяаршлын тулгамдсан асуудлыг тусгасан байна.	Агуулга нь суралцагчдын сонирхол хэрэгцээнд нийцэж, ахуй амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн, нээлттэй байна.	Агуулга нь шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн ололтыг тусгасан,мэдлэгийн бусад салбартай холбогдсон байна.	Монгол улсын түүх, соёл, уламжлал, хөгжлийн үнэт зүйлсээс тухайн агуулгын онцлогт тохируулан заавал тусгасан байна.	Агуулгын багтаамж, бүтэц нь сургалтын төлөвлөгөөнд нийцсэн байх	Нийт шаардлагын тоо	Тохирч буй шаардлагын тоо	Шаардлагын чанарын индекс /Хувиар/
1	01	1	1	1	0	0	0	0	0	0	1	9	4	44.4
2	02	0	0	0	0	0	0	1	1	0	0	9	2	22.2
3	03	0	0	0	0	0	0	1	1	1	0	9	3	33.3
4	04	1	0	0	1	0	0	0	0	1	0	9	3	33.3
5	05	1	0	0	0	0	0	0	0	0	0	9	1	11.1
6	06	1	0	0	1	1	1	1	1	0	1	9	7	77.7
7	07	0	1	1	1		0	0	0	0	0	9	2	22.2
8	08	1	0		1	0	0	1	0	0	0	9	3	33.3
9	09	1	1		0	0	0	1	1	0	0	9	4	44.4
10	010	1	0		0	0	0	1	0	0	0	9	2	22.2
	Нийтлэг үзүүлэлтийн тоо / давтамж	7	3		5	1	1	6	4	2	2			
	Хувь	70	30		50	20	10	60	40	20	20			

Тайлбар: Хэвлэмэл сурах бичгийн арга зүйд тавих шаардлага эрдэмтэн, судлаачдын судалгааны үр дүнтэй тохирч байвал 1 оноо, тохирохгүй бол 0 оноо

Дээрх судалгааны дүнгээс үзэхэд агуулга нь шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн ололтыг тусгасан байх; ухагдахуун, хууль, зүй тогтлыг хэрэглээ болон танин мэдэхүйн

түвшинд тохируулан буулгаж, зөв оновчтой томъёолох шинжлэх ухааны хувьд алдаагүй байх; суралцагчдын сонирхол хэрэгцээнд нийцэж, ахуй амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх, мэдлэгийн бусад салбартай холбогдсон байх шаардлага; танин мэдэхүйн хөгжлийн үе шат, нас сэтгэхүйн онцлогт тохирсон, боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж

холбоог хангасан байх шаардлагууд 40-70 хувьтай; монгол улсын хөгжлийн болон даяаршлын тулгамдсан асуудлыг тусгах; монгол улсын түүх, соёл, уламжлал, хөгжлийн үнэт зүйлсээс тухайн агуулгын онцлогт тохируулан заавал тусгасан байх; дидактикийн оновчтой шийдлээр агуулгын нэгжийг томсгон нэгжилж, бүтэцчилэх үндсэн дээр агуулгын айн инвариант чанарыг хангасан байх; агуулгын багтаамж, бүтэц нь сургалтын төлөвлөгөөнд нийцэж, хичээлийг төлөвлөх, зохион байгуулах нөхцөлийг хангасан байх; боловсролын стандартын цогц чадамжийн ай бүрийн агуулгыг боловсролын болон суралцагчийн танин мэдэхүйн тухайн түвшинд бүрэн эзэмших боломжтой, тэдний мэдлэг бүтээх үйл ажиллагаа нь үр өгөөжтэй байхаар сурах бичгийн агуулгыг сонгох шаардлагууд 10-30 хувьтай Монголын эрдэмтдийн сурах бичгийн агуулгад тавих шаардлагын судалгааны үр дүнтэй тохирч байна. (Хүснэгт 3-т харуулав.)

Сурах бичгийн арга зүй, түүнд тавих шаардлагын судалгаа

Судлаач Н.Цэдэвсүрэн сурах бичгийн арга зүйн таван шаардлагыг боловсруулжээ. Тухайлбал, дасгал даалгавар нь хоёр, хоёроороо болон хэсэг бүлгээр ажиллах боломжийг хангасан байх; тухайн анги, бүлгийн суралцагчдын мэдлэг, чадварын түвшинд нь тохирсон; хүнд хөнгөнөөр өөр түвшинд зохиогдсон дасгал даалгавруудтай байх, зөв зохицсон, системтэй, сэргээн санах даалгавартай байх; зөв байрлуулсан, нэгтгэн дүгнэх даалгавартай байх; тэдгээр нь суралцагчдын үзсэн, сурсан зүйлсийг нь өмнө нь хийж байгаагүй арга хэлбэрээр хийлгүүлж, шалгаж чадахаар боловсруулсан байх хэмээн тодорхойлсон байна.

Судлаач Ж.Нарантуяа сурах бичгийн арга зүйн зургаан шаардлагыг боловсруулсан байна. Тухайлбал, Суралцагчийн сурах сонирхлыг сэдэлжүүлэх; хувь хүний чадвар, чадамжийг хөгжүүлэх; суралцагчийн нийгмийн чадваруудыг хөгжүүлэх; суралцагчийн асуудал шийдвэрлэх, учир шалтгааныг илрүүлэх; шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; мэдлэг бүтээх арга зүй болон сургалтын уламжлалт аргыг хослуулах зэрэг шаардлагуудыг багтаасан байна.

Гадаад хэлний сурах бичгийн арга зүй, түүнд тавих шаардлагыг доорх агуулгаар тодорхойлсон байна. Үүнд: дасгал, даалгавар хангалттай оруулах; суралцагчдын сэтгэн бодох чадварыг хөгжүүлэхэд чиглэх; суралцагчид өөрийгөө шалгах асуулт, даалгавартай байх; суралцагчид алдаагаа олж, засахад сурах бичиг

туслахаар байх; гүнзгийрүүлж үзэх материалын холбогдолтой мэдээлэлтэй байх; сурах бичиг бие дааж сурахад удирдамж болж байх; хичээл тэмдэглэх сайн аргыг сурах бичигт зөвлөмж болгох; хичээл хэрхэн зөв хийх шилдэг аргуудыг сурах бичигт тусгах; ой тогтоомжоо сайжруулах аргыг санал болгох, дасгал, даалгавар хийх аргыг зааж тайлбарлаж өгөх; конспект хийх, захидал, өргөдөл, баримт, хүсэлт бичих загвартай байх; хамтарч хийх ажил, тоглоомын жишээ, даалгавар хийх заавартай байх; найруулан бичих, зохион бичих даалгавар хийх заавартай байх; практик даалгаврыг бие даан хийх аргуудыг зааж өгсөн байх шаардлагуудыг багтаажээ.

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн профессор багш нарын ном, сурах бичигт тавих үндсэн шаардлагад суралцагч нь мэдлэг, чадварыг бие даан эзэмшиж, практикт асуудалд хэрэглэх боломжтой байхаар боловсруулах; сурган хүмүүжүүлэх ухааны дидактик зарчмуудыг хэрэгжүүлсэн байх; шинжлэх ухааны нарийн төвөгтэй асуудлыг ойлгох, ухаарах, тайлбарлах арга зүйг хялбарчилсан байх; бие даан гүйцэтгэх дасгал, даалгавар, сорил туршилт, төслийн ажлуудын тавилт нь танин мэдэхүйн болон ахуй, амьдралтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх; мэдээлэл олох, ашиглах, боловсруулах, мэдлэг эзэмшүүлэхэд хүснэгт, график, бүдүүвч, зураг, бичвэр зэрэг олон хэлбэрийн аргыг хослуулан хэрэглэсэн байх; суралцагсад үйл ажиллагаагаа бүтээлчээр зохион байгуулж, бүтээл туурвил хийхэд нь туслах арга замыг зөвлөсөн, нэмэлт мэдээллийн эх үүсвэрийг оновчтой сонгон тусгасан байх шаардлагуудыг багтаажээ.

Орчин үеийн сурах бичигт тавих арга зүйн нь хичээлийн жилийн эцэст хүрсэн байх түвшинг тодорхойлох; бүлэг сэдвийн зорилго тодорхой байх; хичээлийн зорилгын тодорхой байдал; шалгах дасгалууд ба сэдвийн өргөслийн хамаарал; суралцагчдын мэдлэгийг шалгах дасгал хангалттай эсэх; чадварыг шалгахад зориулсан дасгалын тоо хэмжээ; суралцагчдын судалгааны ажилд дасгах асуулт, даалгавар, зохион бүтээх чадварыг шалгах даалгавар; сурах бичгийн асуулт, даалгавар ба өмнөх мэдлэг, мэдрэмж зэрэг шаардлагуудаар тодорхойлогджээ (Бэгз, 2010, х.4).

Нийгмийн ухааны сурах бичгийн арга зүй, түүнд тавих шаардлагад даалгаврын тавил нь нийгмийн олон талт үзэгдлийг ажиглах, эргэцүүлэн бодох, суралцагчдын сонирхлыг (нийгэм, соёл, түүхийн гарамгай зүтгэлтэн, алдартай хүмүүсийн тухайн үеийн амьдралын сонирхолтой хэсгээс нь мэдрэх, хамт өнгөрүүлэх,

тэдэнд туслах сэтгэл хөдлөлийг төрүүлэх гэх мэт) татахуйц байх; сурах бичиг дэх агуулгын сонголт, бүтцийн бүрдэл хэсгүүд нь суралцагч бусдын мэдэхгүй шинэ зүйлийг түрүүлэн мэдэж, өөртөө “нээлт” хийсэндээ баярлах, бахдах сэтгэл хөдлөлийг бий болгож, улмаар хэний ч шахалт, шаардлагагүйгээр сурах бичигтэй ажиллах сэдэл тэмүүлэл, үйлийг дэмжихүйц байх; танин мэдэхүйн болон ахуй амьдралтай холбоотой (өөрсдийн хүсэл сонирхлын дагуу туршилт, бичил судалгаа хийх гэх мэт) асуудал шийдвэрлэх арга зүйн шийдэлтэй байх; бие даан болон багаар ажиллах дасгал, даалгаврууд нь сэдвээс асуудал дэвшүүлсэн, асуудлаас сэдвийг ургуулан хэлэлцүүлсэн, түүнийгээ жишээ баримтаар нотолж, тайлбарлаж, үндэслэн, сэтгэл хөдлөл хандлагаа илэрхийлэхүйц байх; асуудал, тохиолдлын болон төсөлт судалгааны тавилтай

байхын зэрэгцээ тухайн насны суралцагчдын мэдлэг, туршлагын хуримтлалтай нь уялдуулсан байдал; график, хүснэгт, бүдүүвч, зураглал, тооцооллын арга хэлбэрийн тусламжаар өөртөө мэдлэг бүтээх оновчтой шийдэлтэй байх; нийгмийн амьдралын талаарх сүүлийн үеийн статистик мэдээлэл, баримтад түшиглэсэн, энэ талаар нэмэлт мэдээлэл, эх сурвалжийг бие даан болон бусдын дэмжлэгтэйгээр олох, боловсруулах, солилцох арга технологитой байх; шинээр сурч мэдсэн зүйлийнхээ талаар бүтээлч өдрийн тэмдэглэл хөтлөх, үзэсгэлэн гаргах, бусдад танилцуулах зэрэг шаардлагуудыг оруулсан байна (Дэлгэрсайхан, 2013, х.112). Д.Гарвины арга зүйд тавих шаардлага нь суралцагчдын сэтгэхүйг хөгжүүлэх төрөл бүрийн үйл ажиллагаа, дасгал даалгаврыг багтаажээ

Хүснэгт 2

Одоо мөрдөж байгаа сурах бичгийн арга зүйд тавих шаардлагыг монголын эрдэмтдийн сурах бичгийн арга зүйд тавих шаардлагатай харьцуулсан судалгааны дүн

	Арга зүйд тавих шаардлага	Эрдэмтдийн нэр	Тухайн агуулгыг эзэмшүүлэх арга зүйг суралцагчийн танин мэдэхүйн болон эзэмшихүйн зүй тогтолд нийцсэн үйлийн баримжааг ерөнхий, гүйцэл, бусад асуудалд зөөж хэрэглэх боломжтой байхаар боловсруулна.	Сурах бичгийн агуулгын нэгжүүд ба арга зүйн сонголт нь зөв хосолж, даалгаврын нөхцөл нь суралцагчдыг нээлттэй байлгах, хөгжүүлэх, сэтгэх шийдлүүдтэй байна.	Тухайн боловсролын агуулгын айгаар тодорхойлсон цогц чадамжийг эзэмшүүлэх арга зүйг сонгон хэрэгжүүлж, харгалзах боловсролын түвшний цогц чадамжийг төлөвшүүлэхэд чиглэсэн байна.	Шинжлэх ухааны нарийн төвөгтэй асуудлыг суралцагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохируулан хялбаршуулан боловсруулна.	Агуулгын бүтцийн элемент бүрд суралцагчдын сэдэл, хэрэгцээг үндэслэл сайтай гаргана.	Бие даан гүйцэтгэх дасгал даалгавар, сорил, туршилт, төслийн ажлуудын тавил нь танин мэдэхүйн болон ахуй, амьдралтай холбоотой асуудал шийдвэрлэх арга зүйд суурилсан байна.	Мэдээлэл олох, ашиглах, боловсруулах, мэдлэг бүтээхд хүснэгт, график, бүдүүвч, зураг, бичвэр зэрэг мэдээллийн арга, хэлбэрийг оновчтой хослуулан хэрэглэнэ.	Суралцагчдад үйл ажиллагаагаа бүтээлчээр зохион байгуулж, нээлт бүтээл хийхэд нь туслах арга замыг зөвлөн, нэмэлт мэдээллийн эх үүсвэрийг оновчтой сонгож тусгана.	Нийт шаардлагын тоо	Тохирч буй шаардлагын тоо	Шаардлагын чанарын индекс (хувь)
1	01		0	1	1	0	1	0	0	0	8	3	37.5
2	02		1	1	0	0	0	0	0	1	8	3	37.5
3	03		0	0	1	0	0	0	0	0	8	1	12.5
4	04		0	1	1	1	1	1	1	1	8	7	87.5
5	05		0	0	1		0	0	0	0	8	1	12.5
6	06		1	0	0	1	0	1	1	1	8	5	62.5
7	07		0	1	0	0	0	0	0	0	8	1	12.5
8	08		0	0	0	0	0	0	0	1	8	1	12.5
9	09		1	1	0	1	0	0	1	0	8	4	50
10	010		0	1	1	0	0	0	0	1	8	3	37.5
	Н и й т л э г үзүүлэлтийн тоо / давтамж		3	6	5	3	2	2	3	5			
	Хувь		33.3	66.6	55.5	33.3	22.2	22.2	33.3	55.5			

Тайлбар: Хэвлэмэл сурах бичгийн арга зүйд тавих шаардлага эрдэмтэн, судлаачдын судалгааны үр дүнтэй тохирч байвал 1 оноо, тохирохгүй бол 0 оноо

Дээрх судалгааны дүнгээс үзэхэд суралцагчдад үйл ажиллагаагаа бүтээлчээр зохион байгуулж, нээлт бүтээл хийхэд нь туслах арга замыг зөвлөн, нэмэлт мэдээллийн эх үүсвэрийг оновчтой сонгож тусгасан байх; тухайн боловсролын агуулгын айгаар тодорхойлсон цогц чадамжийг эзэмшүүлэх арга зүйг сонгон хэрэгжүүлж, харгалзах боловсролын түвшний цогц чадамжийг төлөвшүүлэхэд чиглэсэн байх; агуулгын нэгжүүд ба арга зүйн сонголт нь зөв хосолж, даалгаврын нөхцөл нь суралцагчдыг нээлттэй байлгах, хөгжүүлэх, сэтгэх шийдлүүдтэй байх шаардлагууд 55-66.6 хувиар; шинжлэх ухааны нарийн төвөгтэй асуудлыг суралцагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохируулан

хялбаршуулан боловсруулах; мэдээлэл олох, ашиглах, боловсруулах; мэдлэг бүтээхэд хүснэгт, график, бүдүүвч, зураг, бичвэр зэрэг мэдээллийн арга, хэлбэрийг оновчтой хослуулан хэрэглэсэн байх; тухайн агуулгыг эзэмшүүлэх арга зүйг суралцагчийн танин мэдэхүйн болон эзэмшихүйн зүй тогтолд нийцсэн үйлийн баримжааг ерөнхий, гүйцэд, бусад асуудалд зөөж хэрэглэх боломжтой байхаар боловсруулах шаардлагууд 33.3 хувиар; агуулгын бүтцийн элемент бүрд суралцагчдын сэдэл, хэрэгцээг үндэслэл сайтай гаргасан байх; бие даан гүйцэтгэх дасгал даалгавар, сорил, туршилт, төслийн ажлуудын тавил нь танин мэдэхүйн болон ахуй, амьдралтай холбоотой асуудал шийдвэрлэх арга зүйд суурилсан байх шаардлагууд нь 22 хувиар Монголын эрдэмтдийн арга зүйд тавих шаардлагуудтай тохирч байна. (2 дугаар хүснэгтэд харуулав.)

Хүснэгт 3

Хэвлэмэл сурах бичгийн агуулгад тавих шаардлагыг боловсронгуй болгосон үр дүн

Хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага (Одоо мөрдөж байгаа)	Сурах бичгийн агуулгыг боловсронгуй болгох шаардлага, шалгуур үзүүлэлт
-Агуулга нь танин мэдэхүйн хөгжлийн үе шат, нас сэтгэхүйн онцлогт тохирсон, боловсролын түвшин, анги, бүлэг, сэдэв хоорондын залгамж холбоог хангасан байх -Ухагдахуун, хууль, зүй тогтлыг хэрэглээ болон танин мэдэхүйн түвшинд тохируулан буулгаж, зөв оновчтой томъёолсон, шинжлэх ухааны хувьд алдаагүй байх -Агуулга нь суралцагчдын сонирхол хэрэгцээнд нийцэж, ахуй амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн, нээлттэй байх -Дидактикийн оновчтой шийдлээр агуулгын нэгжийг томсгон нэгжилж, бүтэцчилэх үндсэн дээр агуулгын айн инвариант чанарыг хангасан байна. -Агуулга нь шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн ололтыг тусгасан,мэдлэгийн бусад салбартай холбогдсон байна. Эдгээр нийт шаардлагыг $\sum_{i=1}^n A_i$ тэмдэглэв.	-Тогтвортой хөгжлийн хөтөч болох байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийн талаар тусгасан байх (Эдийн засаг –хүрээлэн буй орчин- нийгмийн хөгжлийн талаарх асуудлыг тогтолцоогоор харуулах даалгавар боловсруулсан байх.) -Агуулга нь жендэрийн мэдрэмжтэй байдлыг тусгасан байх. (Сурах бичгийн сэдвүүд жендэрийн мэдрэмжийг тусгасан эсэх) -Онол, практикийн тэнцвэртэй харьцаатай байх. (Сурах бичгийн нийт сэдэв шинжлэх ухааны мэдлэг эзэмшүүлэхэд чиглэж бичигдсэн эсэх, сурах бичгийн нийт сэдэв онол ба туршилт ажлын харьцааг хангасан байх, сурах бичгийн нийт сэдэв онол ба дадлага ажлын харьцааг хангасан байх) Эдгээр нийт шаардлагыг $\sum_{i=1}^n B_i$ тэмдэглэв. Тайлбар: Шалгуур, үзүүлэлтийг дугуй хаалтад хийсэн.

Хүснэгт 4

Хэвлэмэл сурах бичгийн арга зүйд тавих шаардлагыг боловсронгуй болгосон үр дүн

Сурах бичигт тавих арга зүйн шаардлага (Одоо мөрдөж буй)	Арга зүйг боловсронгуй болгоход тусгах шаардлага, шалгуур үзүүлэлт
- Тухайн агуулгыг эзэмшүүлэх арга зүйг суралцагчийн танин мэдэхүйн болон эзэмшихүйн тогтолд нийцсэн үйлийн баримжааг тодорхой, гүйцэд, бусад асуудалд зөөж хэрэглэх боломжтой байхаар боловсруулна.; - Бие даан гүйцэтгэх дасгал даалгавар, сорил, туршилт, төслийн ажлуудын тавил нь танин мэдэхүйн, ахуй, амьдралтай холбоотой асуудал шийдвэрлэх арга зүйд суурилсан байна; - Мэдээлэл олох, ашиглах, боловсруулах, мэдлэг бүтээхэд хүснэгт, график,бүдүүвч, зураг, бичвэр зэрэг мэдээллийн арга, хэлбэрийг оновчтой хослуулан хэрэглэнэ; Дээрх арга зүйн шаардлагыг $\sum_{i=1}^n C_i$ тэмдэглэв.	Суралцагч өөрийгөө сорих асуулт, даалгавар тусгасан байх (Нэгж, ээлжит, бүлэг сэдвийг үнэлэх асуулт, даалгавар нь танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, нийгэмшил, хөдөлгөөн- ур дүйн чадвар эзэмшүүлэхээр боловсруулсан эсэх); -Сэтгэхүйн үйл, үйлдлийг эзэмшүүлэхүйц дасгал, даалгавартай байх (задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах, ангилах, бүлэглэх, хөрвүүлэх, холбоо хамаарлыг тайлбарлах, учир шалтгаан, үр дагавар тайлбарлах бүтээх үйл, үйлдэл хийлгэх); Дээрх арга зүйн шаардлагыг $\sum_{i=1}^n D_i$ тэмдэглэв.

Одоо мөрдөгдөж буй сурах бичигт тавих арга зүйн шаардлага $\sum_{i=1}^n C_i$ - ыг $\sum_{i=1}^n D_i$ гэсэн арга зүйн шаардлагаар баяжуулах нь зохистой байна.

Дүгнэлт

1.Сурах бичгийн талаарх төрөөс баримтлах бодлого, бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийн зорилго, зорилтын хүрээнд нийцүүлэн Бага дунд боловсролын хэвлэмэл сурах бичгийн агуулгад 3 шаардлагад хамааралтай 5 шалгуур, арга зүйд 2 шаардлагад хамааралтай 2 шалгуур үзүүлэлтийг судалгаанд үндэслэж тогтоосон. Үүнд,

Агуулгад тавих шаардлага, шалгуур: Тогтвортой хөгжлийн хөтөч болох байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийн талаар тусгасан байх (Эдийн засаг –хүрээлэн буй орчин- нийгмийн хөгжлийн талаарх асуудлыг тогтолцоогоор харуулах даалгавар боловсруулсан байх); жендэрийн мэдрэмжтэй байдлыг тусгасан байх (Сурах бичгийн сэдвүүд жендэрийн мэдрэмжийг тусгасан эсэх); онол, практикийн тэнцвэртэй харьцаатай байх (Сурах бичгийн нийт сэдэв шинжлэх ухааны мэдлэг эзэмшүүлэхэд чиглэж бичигдсэн эсэх, сурах бичгийн нийт сэдэв онол ба туршилт ажлын харьцааг хангасан байх, сурах бичгийн нийт сэдэв онол ба дадлага ажлын харьцааг хангасан байх);

Арга зүйд тавих шаардлага, шалгуур: Суралцагч өөрийгөө сорих асуулт, даалгавар тусгасан байх (Нэгж, ээлжит, бүлэг сэдвийг үнэлэх асуулт, даалгавар нь танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, нийгэмшил, хөдөлгөөн- ур дүйн чадвар эзэмшүүлэхээр боловсруулсан эсэх); сэтгэхүйн үйл, үйлдлийг эзэмшүүлэхүйц дасгал, даалгавартай байх (задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах, ангилах, бүлэглэх, хөрвүүлэх, холбоо хамаарлыг тайлбарлах, учир шалтгаан, үр дагавар тайлбарлах бүтээх үйл, үйлдэл хийлгэх)

2. Сурах бичгийн арга зүй нь өргөн утгаараа суралцагчдын суралцах болон шинжлэх ухаанч арга барил, мэдлэг бүтээх үйл, хандлагыг дэмжсэн дидактик шийдэл юм.

Сурах бичгийн арга зүй нь тодорхой утгаараа сурах бичгийн бүлэг сэдэв бүрд шинжлэх ухаанч, асуудал шийдвэрлэх, мэдээлэлтэй ажиллах, бүтээлч эрэл хайгуул хийх туршилт, дадлага ажил, дасгал, даалгавруудыг боловсруулсан, тэдгээр нь суралцагч бие даан болон хамтарч суралцах арга барил эзэмшихэд нь чиглэсэн дидактик шийдэл юм. Сурах бичгийн арга зүй нь түүнд тавих шаардлага, шалгуур, үзүүлэлтээр тодорхойлогдоно.

3.Сурах бичгийн агуулга нь өргөн утгаараа суралцагчдын шинжлэх ухааны мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлэх, мэдлэг бүтээх үйлийг дэмжсэн дидактик боловсруулалт юм. Сурах бичгийн агуулга нь түүнд тавих шаардлага, шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдоно. Сурах бичгийн агуулга нь тодорхой утгаараа мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлэх, мэдлэг бүтээх үйлийг дэмжсэн бичвэр (шинжлэх ухааны мэдээ, мэдээлэл) болон бичвэр бус (зураг, хүснэгт, график, диаграмм, бүдүүвч гэх мэт) мэдээллийн дидактик боловсруулалт юм.

Ном зүй

- Бэгз, Н. (2005). *Орчин үеийн сурах бичигт тавих шаардлагууд*. 3-4. Улаанбаатар
- Гөлгөө, Д. (2006). *Шинжлэх ухаан технологийн их сургуулийн профессор багш ном, сурах бичигт тавих үндсэн шаардлага*. 5. Улаанбаатар
- Дэлгэрсайхан, Ц. (2013). *Нийгмийн ухааны сурах бичгийн агуулга, арга зүйн уламжлал шинэчлэлийн залгамж холбоо*. 109-112. Улаанбаатар
- Лхагважав, Ч. (1999). *Сургалтын технологийн шинэчлэл*. 53. Улаанбаатар
- Наранчимэг, Н. (1999). *Боловсролын шинэчлэл. Сургалтын технологийн удирдлага*. 226. Улаанбаатар
- Нарантуяа, Ж. (2012). Сурах бичгийн арга зүй. *Боловсрол судлал сэтгүүл, дугаар 82*, 35. Улаанбаатар
- Туяа, Л. (2005). *Гадаад хэлний сурах бичгийн шинжилгээний арга зүйн зарим асуудал*. 44-45. Улаанбаатар
- Цэдэвсүрэн, Н. (2001). *Сурах бичгийн онол, арга зүйн зарим асуудал*. 96. Улаанбаатар
- Цогбадрах, С. (2018). Сурах бичгийн агуулга, арга зүйд тавих шаардлагыг боловсронгуй болгох нь (Биологийн сурах бичгийн жишээн дээр). *Боловсрол судлалын докторын (Ph.D) зэрэг горилсон бүтээл*, 35-37. Улаанбаатар
- Оюунцэцэг, Н., Бурмаа, Б., Алтанцэцэг, М., Намчинсүрэн, Ц., Мөнхтуяа,Ө., Юмчмаа, Г., Лхагвасүрэн, П. (2005). *Байгалийн ухааны хичээлийн соёлын хөгжил*. 5. Улаанбаатар
- Оюунчимэг, Д., Дэнсмаа, Ж. (2013). *Боловсрол судлал, дугаар 96*, 25. Улаанбаатар
- Ичинхорлоо, Ш. (2013). *Онол, хэрэглээ*, 117-118. Улаанбаатар
- Ичинхорлоо, Ш. (2013). *Сургалтын зарим үзэл, онол* 39-40. Улаанбаатар

The results of comparative studies on the content and methodology of Mongolian scholarly textbooks

Tsogbadrakh.S

*Textbook, learning environment, research sector;
Mongolian Institute for Educational Research*

Abstract

This study was coincident findings with Mongolian scientists' requirements on the content and methodology of textbooks that are 10 requirements for the content of primary and secondary education textbooks 10-70 percentage; 8 requirements for methodology of primary and secondary education textbooks 22-66.6 percentage. As finding was developed 3 requirements, 5 criterion on the content of the textbooks; 2 requirements, 2 criterion (sustainable development guide, environmentally and socially and socially balanced development - tasked with developing a systematic issue of economic, environmental and social development; reflecting gender sensitivity - textual topics reflecting gender sensitivity; theoretical and practical equilibrium - the whole topic of writing, whether it is scientific or literate, the whole textbook theory and experimental work, the whole topic of the textbook and the practice of compilations) on the methodology of the textbooks for pursue a policy state and government about textbooks; on the aim and goal of the schedule of the basic and junior education beyond were formulated description by scientific regarding the content and methodology textbook.

Keywords

Content, methodology, requirements, and criteria of the textbook

* Corresponding author: tsogoo.1207@yahoo.com